

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК

БАТЛАВ.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Г.БАЛЖИННЯМ

**“АЖИЛТНУУДАД АЖЛЫН ХУВЦАС ХУДАЛДАЖ АВАХ” КОМПАНИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: ДҮТ-2020-04-36

**Тендер
шалгаруулалтын дугаар:
дугаар:** ДҮТ/2020-01-036

**Улаанбаатар
2020**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Ажилтнуудад ажлын хувцас худалдаж авах” компанийг сонгон шалгаруулах тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 3 сарын 30 өдрийн 10:00 цаг** -аас өмнө **ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ ЦАХИМ СИСТЕМИЙН** хаягаар ирүүлнэ. www.tender.gov.mn

Сонирхсон этгээд тендэрийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорхи хаягаар авч болно. /нэмэлт тодруулгыг/ **Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр, “Диспетчерийн Үндэсний Төв ХХК”, Үнэлгээний хорооны нарийн бичгийг дарга Б.Азжаргал №418 тоот өрөө, Утас-976 70041371-252 хаягаар ирүүлнэ үү**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 3-р сарын 30** -ны өдрийн **10:30** -т нээнэ.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны

МЭДЭГДЭЛ дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендер оролцогч нь дараах мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Компанийн танилцуулга Компанийн гэрчилгээний хуулбар Татварын тодорхойлолт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт Сүүлийн нэг жилийн баталгаажсан санхүүгийн тайлан Бараа нийлүүлэлтийн хуваарь Нийлүүлэх бараа материалын үзүүлэлт, баталгаат хугацааны мэдээлэл <p>ЖИЧ: Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Багц-1 Импортын бараа байна.</p> <p>Багц-2 Дотоодын давуу эрх тооцно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр, “Диспетчерийн Үндэсний Төв ХХК”, 4 давхар 418 тоот</p> <p>Огноо: 2020 оны 3 сарын 30</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр, “Диспетчерийн Үндэсний Төв ХХК”</p> <p>Огноо: 2020 оны 3 сарын 30</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцтай</p> <p>Багц 1: Диспетчер инженерүүдийн хувцас, гутал</p> <p>Багц 2: Ажлын хувцас, гутал</p>

Багц-1

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. Ерөнхий шаардлага:

- 1.1 Дүрэмт хувцас нь гадна материал нь цэвэр сайн чанарын даавуу байх ба өнгөн хэсэгт шарик үүсэхгүй байх.
- 1.2 Дүрэмт хувцас болон өмд хар хөх өнгөтэй байх ба дотор материал нь сэмрэхгүй, цахилгаанжихгүй, сайн чанарын материал байх.
- 1.3 Дүрэмт хувцас нь загвар, материал, хийц, өнгө сайтай будаг гардаггүй байх.
- 1.4 ХАБЭА Монгол улсад мөрдөгдөж буй шаардлага стандартад нийцсэн байна.
- 1.5 Тендерт оролцогч нь нэг буюу хэд хэдэн загварыг санал болгож болно.
- 1.6 Оёдол хийц, материалын хувьд 6 сарын баталгаа өгнө.
- 1.7 Хувцасны зохион бүтээлт нь өмсөх үед биед эвтэйхэн, ажил хөдөлмөр эрхэлхэд саад болохгүй байх.
- 1.8 Гутал нь чийг татахгүй, өмсөхөд хөлд эвтэйхэн байх.

Нийлүүлэх барааны жагсаалт

№	Нийлүүлэх барааны төрөл	Тоо хэмж	Хэмжих нэгж
1	Эрэгтэй пиджак, өмд	9	ш
	сорочик	18	ш
	зангиа	9	ш
	гутал	9	хос
2	Эмэгтэй пиджак, өмд	1	ш
	сорочик	2	ш
	зангиа	1	ш
	гутал	1	хос

Багц-2


АЖИЛЧДЫН АЖЛЫН ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. Ерөнхий шаардлага:


- 1.1 Ажилтан бүрийн биеэс хэмжээ авна.
- 1.2 Ажлын хувцасны материал нь цэвэр сайн чанарын даавуу байх ба өнгөн хэсэгт шарик үүсэхгүй байх.
- 1.3 Ажлын хувцас нь саарал өнгөтэй байх ба дотор материал нь сэмрэхгүй, цахилгаанжихгүй, өнгө дагуу сайн чанарын материал байх.
- 1.4 Ажлын хувцасны хослол нь загвар, материал, хийц, өнгө сайтай будаг гардаггүй байх.
- 1.5 ХАБЭА Монгол улсад мөрдөгдөж буй MNS ISO 13688:2000 шаардлага стандартад нийцсэн байна.
- 1.6 Санал болгож байгаа загвараас нэг ширхэгийг битүүмжлэн тендерийн материалын хамт газарт ирүүлнэ.
- 1.7 Дотрын материал нь гадуур хувцсыг өмсөх, тайлахад хялбар байлгах, дотро талд өссөн хувцастай барьцаалдахгүй байлгах зориулалт бүхий материал байх
- 1.8 Диагноль хээ үүсгэн нэхсэн даавуу
- 1.9 Тухайн хувцасны дотор талд давхар үе болгон хийсэн дулаалга
- 1.10 Бат бөх хийгдсэн, эдийн засгийн үр ашигтай байна
- 1.11 Баруун ханцуйнд мөрний залгаас оёдлоос доош 10 см байрлалд 55 мм диаметртэй дугуй логог хатгаж оёсон байна.
- 1.12 Ажлын цамцны уртыг тухайн ажилтны биеэс хэмжээ авч тохируулна.
- 1.13 Ажлын хуцасны хослол нь өвөл, хавар, намар болон зуны улиралд өмсөх 2 төрөл байна.
- 1.14 Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх
- 1.15 Хөдөлгөөн хийхэд саадгүй хүний биед харшлахгүй байх
- 1.16 Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумны түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй байх. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байх
- 1.17 Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Оуулгын өнгө саарал байна.

Хоёр. Ажлын хувцасны загвар болон зохион бүтээлт

- 2.1 Хувцасны загвар ба хэмжээ нь өмсөх хүний ая тухыг боломжтой байдлаар хангах ба хөдөлгөөнд саад болохооргүй байна.
- 2.2 Хувцасны зохион бүтээлт нь түүнийг өмсөх үед биед эвтэйхэн, ажил хөдөлмөр эрхлэхэд саад болохгүй байна.
- 2.3 Үйлдвэрлэлийн болон гадны нөлөөллөөс хамгаалах чадвар сайтай байх.
- 2.4 Өвлийн хувцас нь биеийн болон гарын чөлөөт хөдөлгөөнийг хангах зорилгоор ханцуйн урд хэсгийн оруулгыг энгэрийн хажуугийн босоо оруулгатай босоо нэг бүрдэл хэсэг байхаар хийнэ.
- 2.5 Хөдөлгөөний чөлөөтэй байдлыг хангах оёдол, зохион бүтээлт, зүсэлт нь 1-2-р зурагт үзүүлсний дагуу байна
- 2.6 Зурагт үзүүлсэн загвараар хийх ба өнгө нь цамцны өнгөтэй ижил байна.



1-р зураг : Гарын чөлөөт хөдөлгөөнийг хангах оруулга



Гурав: Өвлийн хувцасны загвар

3.1 Хүрэмний загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

а Товчлоосоор салхи орох, дулаан алдахаас сэргийлэх даралт /планктай/ дарсан

б Дотрын дотроос салдаг үндсэн дулаалга болон дотроос салдаг нэмэлт дулаалгатай

в Дотроос салдаг дулаалгыг тайлснаар хавар, намрын улиралд дотрын дотроос салдаг дулаалгатай өмсөнө. Дотрын дотроос салдаг дулаалгыг тайлснаар хүрэмний өнгө, гадар дангаараа үлдэж цэвэрлэгээ, угаах үед хялбар байх

г Бүч бүхий малгайтай

д дулаалагатай захтай

е Ханцууйн үзүүрийн дотор талд салхи орохос хамгаалах зангуу товчоор чангардаг байна.

ё Бүсэлхийн хэсэгт салхи орохос хамгаалж дотор талдаа гүйдэг уятай бүстэй байна.

ж Далд товчлоостой эсвэл цахилгаантай байна

з Энгэрийн дээд хэсэгтээ тагтай халаастай. Ташаандаа эзлэхүүнтэй ил халаастай и Энгэр, ар нуруунд гэрэл ойдог туз болон оруулгатай

2.2 Өмдний загвар, хийцэд дараах зохион бүтээлтийн хийцүүдийг тусгасан байна

а Нуруугаар салхи орохоос хамгаалах комбинзон, бүсэлхийгээрээ сунаж агших чөлөөтэй өмсөх резинэн оруулгатай. Комбинзоны мөр нь уртасгаж, богиносгох зориулалттай резинэн мөртэй, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой өвдгөнд 2 хуниастай байна.

б Дотрын дотроос салдаг үндсэн дулаалга болон дотроос салдаг нэмэлт дулаалгатай байна. Дулаалгын шумгийн хэсэгт сүлжмэл манжеттай байна. Дотроос салдаг дулаалгыг тайлснаар хавар, намрын улиралд өмсөх бололцоотой болно. Дотрын дотроос салдаг дулаалгыг тайлснаар өмдний өнгө, гадар дангаараа үлдэж цэвэрлэгээ, угаах үед хялбар болгох

в Өвдөгний хэсэгт давхарлагатай

г Арын суудлын хэсэгт давхарлагатай


д Ташааны оёдолд орсон халаастай


е Хоёр хажуу талдаа тагтай эзлэхүүнтэй ил халаастай

ё Шуумагийг зангуу товчоор нарийсгах боломжтой


ж Өвлийн дулаалгатай хүрэм, өмдний загвар, хийц, зохион бүтээлт нь 1-р зурагт үзүүлсний дагуу байна.

1-р зураг : Өвлийн хувцасны загвар





2.1 Зуны хувцасны загвар



ё/Энгэрийн зүүн халаасны дээд талд “ДҮТ ХХК” ХК гэж шар өнгөөр оёно. Үсгийн өндөр нь 1,5см өргөн нь 1 см байх ба оёсны өргөн 3 мм шар өнгөтэй байна.

б/ Зүүн ханцуйн мөрний залгаасаас доош 10 см орчимд компанийн логоны дээд ирмэг байхаар оёно.

Дөрөв. Энгэрийн тэмдэг.

- 4.1 Эрэгтэй энгэрийн тэмдэг нь 10 мм диаметртэй байгууллагын брэндбүүк дэх лого дугуй хэлбэртэй байна.
- 4.2 Материалын хувьд өгнө хувирдаггүй шар өнгийн металъ, эдэлгээ даах хатгадаг нарийн зүйтэй байна.

Тав. Үйлчилгчийн хувцас, шаахай

- 5.1 Биеэд эвтэйхэн сайн чанарын цэнхэр, хар хөх өнгийн цэвэр даавуун материалыаар Зураг 5 үзүүлсэн загварын дагуу хийгдсэн байх.
- 5.2 Шаахай нь арьс юмуу агаар сайн нэврүүлдэг сайн чанарын материалыаар хийгдсэн.
- 5.3 Хөнгөн, халтиридаггүй хөлд эвтэйхэн цагаан өнгөтэй байх.

Нийлүүлэх барааны жагсаалт

№	Нийлүүлэх барааны төрөл	Тоо хэмж	Хэмжих нэгж
1	Ажлын зуны нормын хувцас	38	ш
2	Ажлын өвлүйн нормын хувцас	6	ш
3	Үйлчилгчийн хувцас	2	ш
4	Ажлын зуны гутал	40	



Зураг 8 /компанийн лого/

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хуртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (<i>Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө</i>)
1	2	3	4	5	6	7	8
[Дугаар бичих]	[Барааны товч тодорхойлолтыг бичих]	[Ингэжийн тоо ширхэгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Багц- 1

1	Эрэгтэй иж бүрэн дүрэмт хувцас	9	ш	ДҮТ ХХК	30 хоног	60 хоног	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
2	Эмэгтэй иж бүрэн дүрэмт хувцас	1	ш	ДҮТ ХХК	30 хоног	60 хоног	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
3	Гутал	10	ш	ДҮТ ХХК	30 хоног	60 хоног	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа

Багц- 2

4	Ажлын зуны нормын хувцас	38	ш	ДҮТ ХХК	30 хоног	60 хоног	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
---	--------------------------	----	---	---------	----------	----------	--------------------------------------

5	Ажлын өвлийн нормын хувцас	6	ш	ДҮТ ХХК	30 хоног	60 хоног	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
6	Үйлчлэгчийн хувцас	2	ш	ДҮТ ХХК	30 хоног	60 хоног	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
7	Ажлын зуны гутал	40	ш	ДҮТ ХХК	30 хоног	60 хоног	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Диспетчерийн Үндэсний Төв ХХК)-ын гүйцэтгэх захирал Г.Балжинням танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг барааг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор 100 хувь хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| <p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p> | <p>1.1. Техникийн тодорхойлолтод заасны дагуу материал, хийцийн шаардлага хангахгүй бараа нийлүүлсэн тохиолдолд гэрээ байгуулахаас татгалзана</p> |
| <p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;3) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| <p>4. Төлбөр (ГЕН – 7)</p> | <p>4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн ¹⁰⁰ хувийг барааг хүлээн авсан акт, мөн гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг болон санхүүгийн баримт, бараа хүлээж авсан актыг үндэслэн төлнө.</p> |
| <p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹</p> | <p>6.1. Алданги оногдуулах хувь: 0.5%
Алдангийн нийт дүн: 10%</p> |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож
_____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүний хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

